


**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ
2020 ОНЫ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ЭМЧ ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДААС
АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 11 дүгээр сарын 29

Улаанбаатар

**Эмч, эмнэлгийн ажилчдаас авсан сэтгэл ханамжийн үнэлгээ,
үнэлгээний дагуу авсан арга хэмжээнүүд**

2020 оны байдлаар 59 асуумж бүхий 5 дэд сэдвээр 83 эмч, эмнэлгийн ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан нь нийт ажиллагсдын 53% хамрагдсан байна. Үүнээс эерэг сэтгэл ханамж 78,2%-тай байна.




2019 оны эерэг сxs-75,9%

2020 оны эерэг сxs-78,2%

**2019,2020 онд ЭМТҮЧАБА-наас авсан эмч, эмнэлгийн ажилчдын
ажлын хандлагын судалгаа**

2020 онд ЭМТҮЧАБА-с авсан 2 удаагийн ажлын хандлагын судалгаанд давхардсан тоогоор 136 эмч, эмнэлгийн ажилтан буюу нийт ажилчдын 60% нь оролцсон. Нийт 11 асуумжаар авсан. Ерөнхий сэтгэл ханамж 82,2% -н үнэлгээ авсан байна.



Эмч ажилчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дагуу авч хэрэгжүүлсэн ажлууд:

“Таны цалин хэрэгцээнд тань хангалттай хүрдэг үү” гэсэн асуултанд 63,4%-тай оноо авсан байна. 2020 оны 11 дүгээр сарын байдлаар :

Үр дүнгийн урамшуулалд -108,999,331 төг / 10 сарын байдлаар/

Зэргийн нэмэгдэл- 14,423,868 төг/ 10 сарын байдлаар/

Илүү цагийн хөлс- 360,671,464 төг/ 10 сарын байдлаар/

Хортой нөхцлийн нэмэгдэл- 7,895,142 төг/ 10 сарын байдлаар/

Бохирын нэмэгдэл- 3,741,792/ 10 сарын байдлаар/

Хөдөлмөрийн нөхцлийн /хүүхдийн эмч, сувилагч/- 34,109,770 төг/ 10 сарын байдлаар/

Ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл хөлс- 3,579,781 төг/ 10 сарын байдлаар/

Нийт 533,421,148 төг зарцуулсан байна. / 10 сарын байдлаар/

“Танд ажлынхаа хажуугаар суралцах боломж байдаг уу” гэсэн асуултанд 65,5% оноо авсан байна. Үүний мөрөөр хийсэн ажил:

- ✓ Глобал Удирдагч Дээд Сургуулийн шаталсан бакалаварын сургалтанд 3 сувилагч хамрагдаж байна.
- ✓ Интермед эмнэлгийн сургалтын албанаас 2020 оны 03 сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Амилуулах суурь тусламжийн сургагч багш”-ийн сургалтанд 3 сувилагч хамрагдаж амжилттай төгссөн . Мөн 2 их эмч ЭХЭМҮТ-д “Амилуулах суурь тусламжийн сургагч багш”-ийн сургалтанд хамрагдсан.
- ✓ 2020 онд төгсөлтийн дараах сургалтанд 17 эмч, сувилагч нарыг хамруулан нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн.:
- ✓ Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийг дараах мэргэшил олгох сургалтанд НЭМХТ, НЭМГ, АХБ - д хүсэлт гаргаж Хүүхдийн сувилахуй - 4, Мэс заслын сувилахуй - 2, Чих хамар хоолойн сувилахуй -1, эрчимт эмчилгээний сувилахуй

-1, сэргээн засахын сувилахуй-1, цусны сувилахуй -1 нийт 10 сувилагч хамрагдсан.

- ✓ УГТЭ-ийн эрчимт эмчилгээ, харвалт, сэргээн засах эмчилгээний чиглэлээр 1 сарын хугацаатай 8 их эмч суралцсан.
- ✓ Их эмч Б.Мягмарсүрэн, З.Ганчулуун нар “Амьсгалын црчмог хүнд халдваруудын эмнэл зүйн менежмент” сэдэвт 5 хоногийн сургалтанд суусан.
- ✓ Сувилагч тусгай мэргэжилтнүүдийн мэдлэг боловсрол, ур чадварыг дэмжин сайжруулах зорилгоор олон улсын магадлан итгэмжлэгдсэн Интермед эмнэлэгт туршлага судлах дадлага сургалтыг 9 удаа ажлын байран дээр амжилттай зохион байгуулж, сургалтанд – 12 сувилагч хамрагдсан./ Ахлах сувилагч-4 ,сувилагч-8/
- ✓ СХДНЭ-т ХӨСҮТ-ийн их эмч Болормаа Нарантуяа нар “КОВИД -19, Халдварын сэргийлэлт хяналт” сэдвээр 2020.04.17-нд сургалт зохион байгууллаа. Сургалтанд СХДНЭ эмч, ажилчид 29 хүн хамрагдлаа.
- ✓ Мэргэжил дээшлүүлэх сургалт, давтан сургалтанд 2 сувилагч, 1 эмчийг үндсэн цалинтай, Азийн хөгжлийн банкны тэтгэлэгтэй сургалтанд нийт 43 эмч, 23 сувилагчийг хамруулан ажилласан.
- ✓ ЭМТҮЧАБА-с ЭМС-н 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 тоот тушаал, тушаалын 1 ба 2 дугаар хавсралт болох “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах журам, мэдээлэх хуудас”, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн эрсдлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах журам, мэдээлэх хуудас” зэрэг сэдвээр нийт эмч эмнэлгийн ажилтнууд, шинэ ажилтнуудад давтамжтай 4 удаагийн сургалтуудыг хийсэн байна.

“Танай байгууллагад тушаал дэвших боломж хэр байдаг вэ” гэсэн асуултанд 74,5%-тай дунд оноо авсан байна. Энэ чиглэлээр дүүргийн Жишиг Нэгдсэн эмнэлэг баригдаж буйтай холбоотойгоор Эрүүл мэндийн салбарын хөгжил, хөтөлбөр +4 төслийн хүрээнд 10 асрагчийг туслах сувилагчаар сурган төгсгөж ажлын байраар ханган ажиллуулж байна.

“Дэмжлэгт удирдлага” асуумжаар 71,6 %-тай дунд оноо авсан байна.

- ✓ Уг чиглэлийн хүрээнд ажиллагсдын эрүүл мэндийг сэргийлэх, дэмжих зорилгоор элэгний вирусын шинжилгээнд 92 ажилтан, 3 дахь тунгийн дархлаажуулалтанд 30 ажилтан хамрагдсан.
- ✓ Улсад ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан нийт 11 ажилтаны үндсэн цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн.
- ✓ Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газарт ажилтнуудыг зуслангийн газартай болгуулах хүсэлтээ 101 дугаар албан тоотоор хүргүүлэн ажилласан.
- ✓ Олон улсын “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан гэр бүлд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, бие биенээ хайрлах, гэр бүлийн үнэ цэнийг эрхэмлэх,

ээрэг сайхан сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд “Эцэг эхийн зөвлөл”-өөс байгууллагын эмч ажилчдын дунд өдөрлөг зохион байгуулж:

1. “Аав, ээж, би, бид” гэр бүлийн хөгжөөнт тоглоом
2. “Миний гэр бүл- Миний аз жаргал” гар зургийн уралдаан 2 насны ангилалаар
3. “Миний гэр бүл- Миний аз жаргал” эссэ бичлэгийн уралдаан дунд, ахлах ангийн сурагчдын дунд
4. “Байгууллагын сүлд дууг аль тасаг хамгийн сайн дуулах вэ?” дууны уралдаан зэргийг зохион байгуулж байр эзлүүлэн шагнаж урамшуулсан. Өдөрлөгт 5 тасгийн 9 гэр бүл 21 хүүхэд оролцсон.



Шагнал урамшуулал:

Эрүүл мэндийн яамны Жуух—3


Эрүүл мэндийн яамны Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан -3

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Өргөмжлөл-4


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Тэргүүн-1 тус тус шагнагдсан байна.

Үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн үнэлгээ, үнэлгээний дагуу авсан арга хэмжээнүүд

2020 оны жилийн эцсийн байдлаар 300 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан ба энэ нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 8 хувийг хамарч байна. Эерэг сэтгэл ханамж 88,8%-тай байна.



Чанарын албанаас нийт 1300 үйлчлүүлэгчдээс авсан эерэг сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 88,1%-тай гарсан байна.



Үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаагаар байгууллагын соёл асуумжийн Эмнэлгийн гадаад орчны тохижилт гэсэн үзүүлэлтээр эерэг сэтгэл

ханамжийн хамгийн бага хувь болох 69,5%-тай дүн гарсан байна. Энэ ажлын хүрээнд нийт 67 ажилчид байгууллагын ойр орчмын 50м хүртлэх талбайн хог хаягдлыг цэвэрлэж, Гаднах талбайн болон ногоон байгууламжийн нийт 300м хашаа хайс будаж, өнгийг сэргээж тохижуулсан. Мөн бут сөөгийг янзалж цаашид ургах боломжгүй моднуудыг авч газар чөлөөлсөн



Голомт банктэй хамтарч эмнэлгийн гадна орчинд 20 мод тарьсан





Үйлчлүүлэгчийн машины зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж эмнэлгийн орчны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор гадна замыг тэгшилж, сайжруулсан зам тавьж зассан.





Эрүүл мэндийг дэмжих төв байгуулах ажлын хүрээнд амбулаторийн хэсгийг засаж сайжруулан үйл ажиллагааг өргөтгөж эмнэлгийн хүлээгдэл ачааллыг бууруулах зорилгоор одоо ажиллаж байгаа 18 кабинетыг 27 кабинет болгож нэмэгдүүлэхээр НЭМГ-т санал хүргүүлсэн.



Эмнэлгийн дотоод засвар үйлчилгээнд

- 2020 оны байдлаар нийтлэг засвар үйлчилгээний 6,315,055₮-ийн өртөг бүхий ажил
- 2020 оны байдлаар сантехникийн засвар үйлчилгээний 5,194,303 ₮-ийн өртөг бүхий ажил



Мөн эмнэлгийн хүлээгдэл ачааллаар 93,7%-тай дүн гарсан үзүүлэлт байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл чиргэдлийг бууруулах, ажилчдын ажлын ачааллыг бууруулах зорилгоор короновирусын халдвар гарсан цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

1. 2020.01.27-ний өдрийн А/03 дугаар тушаалаар Шинэ короновирусын халдварын үед 2020.03.02 өдөр хүртэл эмнэлгийн тусламж
2. үйлчилгээнд шаардагдах эм эмнэлгийн хэрэгсэл, өвчтний хоол хүнсийг хангалттай хэмжээгээр нөөцөлж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллахыг нийт эмч, эмнэлгийн ажилтанд үүрэг болгов
3. 2020.04.02-ний өдрийн А/03 дугаар тушаалаар А/20 дугаар тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах хариуцлагатай жижүүр томилж ажиллуулах
4. 2020.05.01-ний өдрийн А/26 дугаар тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах хариуцлагатай жижүүр томилж ажиллуулах

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл үзүүлэлтийн эерэг сэтгэл ханамжийн хувь 89,8 % байна.

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 сарын 25-ны өдрийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” 446 дугаар тушаалыг 2019-09-04 өдрийн А/406 тоот тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” болгон шинэчлэн батласантай холбогдуулан тус эмнэлгийн ёс зүйн хэсгийн хорооноос 2020 оны 01 сарын 09,14- ны өдөр нийт эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах сувилагч, ажилчдад “ЭМС-ын 406 тоот тушаалыг танилцуулах” сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд 53 хамрагдсан.



- ✓ Эмч мэргэжилтнүүдийн ёс зүй харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор “Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэе” 2020 оны 4.1-с 4.30 хүртэл 1 сарын аяныг зохион байгуулж аяны хүрээнд нийт ажиллагчдад дотоодын сургалтыг 2 удаа зохион байгуулсан.



- ✓ Эмч эмнэлэгийн ажилчид өдөр бүр инээмсэглэл, эерэг хандлагыг бусдад түгээж, эмч, ажилтан бүр хамт олноороо эерэг харилцааг хэвшил болгож байгууллагынхаа соёлыг сайжруулахын төлөө хүн бүхэн идэвхитэй санаачлагатай байж өөрчлөлтийг өөрөөсөө эхлэх уриалга эхлүүлж, “Эерэг хандлага” – эмчилгээний эхлэл” 3 сарын аяныг 2020.10.15-12.15-ны хооронд явагдаж байна. Ажлын бүтээмж, чанараа улам батжуулахын тулд “Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” хүрээнд эмч ажилтнууд дунд “Халуун сэтгэл – Халуун цай” өдөрлөгийг зохион байгуулж ажилтнуудыг өглөө цага бүртгүүлэхээр ирэхэд нь халуун чацаргана, цай, кофегоор дайлан шинэ 7 хоногийг хөгжилтэйгээр эхлүүлээ. Нийт ажилтнууддаа ажлын амжилт, эрч хүчийг хүслээ.



“Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” хүрээнд тасгийн нийт 32 эмч ажиллагсадын дунд амжилттай зохион байгууллаа. Бие биедээ урам хайрласан үг бичиж, талархал илэрхийлж, харилцан туршлага солилцсон байна.



Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг үзүүлэлт өмнөх оныхоос 15%-р өссөн үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор:

- Ижил мэргэжилтний үнэлгээг сар бүр эмч, сувилагч, асрагч нарын дунд хийдэг. 2020 онд тасаг нэгж бүр өвчний түүхэнд эмч нарын дунд ижил мэргэжилтний үнэлгээг 162 удаа удаагийн үнэлгээ хийхэд өвчний түүх хөтлөлт 90,9 %
- Сувилагч нарын дунд нарын сувилгааны түүх, анхан шатны маягт хөтлөлтөнд 481 удаа хийхэд 88,5%
- асрагч нарын дунд цэвэрлэгээ үйлчилгээний үнэлгээг 1079 удаа хийхэд 92,1% байна.

Энэ онд шинээр 12 ш хяналтын хуудас боловсруулан тасаг нэгжид хяналт хийсэн.

- ✓ Эмийн сан,хэвтэн эмчлүүлэх тасагт Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн 1 хяналтын хуудас
- ✓ Эмийн сангийн үйл ажиллагаанд 1 хяналтын хуудас
- ✓ Яаралтай тусламжийн тасгийн бэлэн байдлын 1 хяналтын хуудас
- ✓ Ижил мэргэжилтний үнэлгээний 1 хяналтын хуудас
- ✓ “COVID-19” бэлэн байдлын үнэлгээний 1 хяналтын хуудас
- ✓ “COVID-19” –ын хамгаалах хувцас өмсөх, тайлах 1 хяналтын хуудас
- ✓ Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар аюулгүй байдалд хяналт хийх хяналтын хуудас
- ✓ Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд хяналт хийх хяналтын хуудас
- ✓ Эмийн хэрэглээг хянах шалгуур
- ✓ Лабораторийн чанар, аюулгүй байдлын хяналтын хуудас
- ✓ Венийн судсанд уян зүү тавих үйлдлийг хянах хяналтын хуудас
- ✓ Уян зүүний тандалт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт хийх хяналтын хуудас зэргийг тус тус боловсруулсан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор байгууллагын хэмжээнд дараахь аянуудыг зохион байгуулж ажилласан байна.

- “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг дээдлэе” сэдэвт 1 сарын аян /2020.04.01-04.30/
- “Өвчний түүх бичилтийг сайжруулах” сэдэвт 3 сарын аян /2020.10.13-12.13/
- “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал-таны гарт” сэдэвт 1 сарын аян /2020.10.16-11.16/
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал-дэлхий өдөр сэдэвт өдөрлөг /2020.09.17/ зэргийг тус тус зохион байгуулсан.

“Нэг хот-нэг стандарт” аяны хүрээнд “Амилуулах тусламжийг багаар үзүүлэх чадварт сургах” жилийн аян зохион байгуулж, 22 сэдвээр 43 удаагийн онол , дадлагын сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 299 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Аяны үр дүнд амилуулах тусламж үзүүлэх мэдлэг,ур чадвар сайжирсан.



Сайн туршлага-2020 уралдаанд 7 бүтээлээр:

- Дүрсийн хяналттай гүрээний венд төвийн венийн гуурс байрлуулах
- Хүүхдийн тусламж үйлчилгээнд олон улсын эмнэл зүйн удирдамж /UPTODATE/ ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эмнэл зүйн удирдамжууд/17 эмнэл зүйн удирдамж батлагдсан/
- Үйлчлүүлэгчийг зөв таних арга, үйлчлүүлэгчийн унахаас сэргийлэх эрсдлийг үнэлэх, түүнээс сэргийлэх журам
- Үйлчлүүлэгчийг таних, хэл ярианы бэрхшээлтэй асран хамгаалагч нартай ярилцах “Дуугүй хөтөч”
- Судасны хэт авиан шинжилгээний үндэс, төвийн венийн катетер байрлуулахтай холбоотой асуудлууд, гүрээний төвийн венийн судасны хүрцийн үйлдлийн заавар
- Коронавирусын халдвар, сүрьеэ өвчнөөс сэргийлэх видеог нэгтгэж тус бүр DVD бэлтгэн сургалт сурталчилгааны ажилд хэрэглэж байгаа хичээл
- Үйлчлүүлэгчид зориулсан рентген шинжилгээний гарын авлага зэрэг бүтээлүүдээр оролцож 3 бүтээл шалгаран гэрчилгээ авч, “Сайн туршлага-2020” номонд орон, бусад бүтээлүүд батламж авсан.



ХЯНАСАН:

СХДНЭ-Н ДАРГА

Б. ГАЛСАНЦЭДЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭМТҮЧАБА-НЫ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Л. ЦЭВЭЛМАА